



**НИЙСЛЭЛИЙН**  
**ХУДАЛДАН АВАХ**  
**АЖИЛЛАГААНЫ ГАЗАР**

**ЦЭЦЭРЛЭГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ /УЛААНБААТАР, ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ,  
17 ДУГААР ХОРОО, 103 ДУГААР ЦЭЦЭРЛЭГ/ НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН  
ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

**Тендерийн нэр:** Цэцэрлэгийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 17 дугаар хороо, 103 дугаар цэцэрлэг/ нийлүүлэх

**Тендерийн дугаар:** НХААГ-20/0039-2

**Улаанбаатар хот**  
**2020**

Голден хоул ХХК-Д  
Төгс эрдэнэт гэрээ ХХК-Д  
Аргил сувд ХХК-Д  
Айон Теч ХХК-Д  
Нэкст электроникс ХХК-Д  
Тольт хөдөлгүүр ХХК-Д

Гэрээ шууд байгуулах урилга хүргүүлэх тухай

Огноо : **2020 оны 06 дугаар сарын 23-ны өдөр**

Тендер шалгаруулалтын нэр: Цэцэрлэгийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 17 дугаар хороо, 103 дугаар цэцэрлэг/ нийлүүлэх

Тендер шалгаруулалтын дугаар: **НХААГ-20/0039-2**

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар эрх бүхий тендерт оролцогчдоос **Цэцэрлэгийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 17 дугаар хороо, 103 дугаар цэцэрлэг/ нийлүүлэх** цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа цахим тендер тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **50 000 (тавин мянга)** төгрөгийг банкны цахим төлбөр тооцооны системийг ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30 хоногийн** дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

**1. Борлуулалтын хэмжээ:**

Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 онуудын борлуулалтын орлогын дундаж нь төсөвт өртгийн 50 хувиас багагүй байна.

**2. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:**

Төсөвт өртгийн 30 хувиас багагүй байх.

**3. Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:** Санхүүгийн тайлан ирүүлэх шаардлагагүй бөгөөд Захиалагч цахим системээр дамжуулан тендерт оролцогчдын 2018, 2019 онуудын санхүүгийн тайлангийн шаардлагатай мэдээллийг татаж үзнэ.

**4. Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо:** Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 оны аль нэг жилд төсөвт өртгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй барааг доод тал нь нэг удаа нийлүүлсэн байна.

**5. Тендерийн баталгааны үнийн дүн:** 2,200,000 /хоёр сая хоёр зуун мянга/ төгрөг

Тендерийг **2020 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 09 цаг 00 минутаас** өмнө системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2020 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 09 цаг 30 минутад** Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын 1012 тоот өрөөнд нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх **эрхтэй**.

Дотоодын давуу эрх **тооцно**.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон холбогдох бусад материалыг [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn), [www.ub-procurement.mn](http://www.ub-procurement.mn) цахим хуудаснаас, бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Бага тойруу-15,

Нийслэлийн Засаг захиргааны IV байр, 10 дугаар давхар,

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар,

Утас: 75757810.

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- |   |  |
|---|--|
| <b>1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа</b> | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.  |
| <b>2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт</b>               | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.<br>2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.<br>2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ. |
| <b>3. Тендерийн иж бүрдэл</b>                           | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:<br>(а) Үнийн санал;<br>(б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;<br>(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;<br>(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;<br>(д) ТШӨХ-д шаардсан бусад нэмэлт материал.   |
| <b>4. Тогтмол үнэ</b>                                   | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.   |
| <b>5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд</b> | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.<br>5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.  |
| <b>6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа</b>           | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.   |

- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p><b>1. Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:</b> Санхүүгийн тайлан ирүүлэх шаардлагагүй бөгөөд Захиалагч цахим системээр дамжуулан тендерт оролцогчдын 2018, 2019 онуудын санхүүгийн тайлангийн шаардлагатай мэдээллийг шалгана.</p> <p><b>2. Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо:</b> Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 онуудын аль нэг жилд төсөвт өртгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй барааг доод тал нь нэг удаа нийлүүлсэн байх. Бараа нийлүүлсэн гэрээний хуулбар, хүлээлгэж өгсөн актын хуулбар, тухайн барааг цаг хугацаанд нь чанартай нийлүүлсэн тухай захиалагчийн тодорхойлолтыг ирүүлнэ/ Ижил төстэй ажилд <b>тоног төхөөрөмж</b> нийлүүлсэн туршлагыг тооцно.</p> <p><b>3. Борлуулалтын хэмжээ:</b> Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 онуудын борлуулалтын орлогын дундаж нь төсөвт өртгийн 50%-иас багагүй байна.</p> <p><b>4. Барааг нийлүүлсний дараах засвар, үйлчилгээ:</b> Барааг нийлүүлсний дараах байнгын болон урсгал үйлчилгээний (засвар) хуваарийг бэлтгэж ирүүлнэ. Баталгаат засварын хугацаа 12 сараас багагүй байх шаардлагатай ба албан бичгээр баталгаажуулан мэдэгдэх шаардлагатай.</p> <p><b>5. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:</b> Төсөвт өртгийн 30 хувиас багагүй байх. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийн аль нэгээр эсвэл [1] болон [2] дахь заалтын нийлбэрээр тус тус тодорхойлно. Үүнд: 1. Байгууллагын дансны үлдэгдэл /Харилцагч банкны/ 2. Арилжааны банкны зээлийн авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолт /Банкны судлан үзэж зээл олгох боломжтой гэсэн тодорхойлолтыг үнэлгээнд харгалзахгүй/. 3. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүнг Сангийн сайдын 2015 оны 343 дугаар тушаалаар батлагдсан “Санхүүгийн тайланд шинжилгээ хийх үлгэрчилсэн загвар”-ын 3.2.2 /е/-д “Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө = Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө + Санхүүгийн хөрөнгө + Дансны авлага гэсэн үзүүлэлтүүдээр дүгнэнэ” гэж заасны дагуу тодорхойлно.</p> <p><b>6. Тендерийн баталгааны үнийн дүн:</b> 2,200,000 /хоёр сая хоёр зуун мянга/ <b>төгрөг</b> Хүчинтэй байх хугацаа:<b>2020 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийг дуустал.</b> Тендерийн баталгааг материалд хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд тендерийн баталгаа гаргагч арилжааны банкнаас цахим системээр тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө ирүүлсэн байна.</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: <b>2020 оны 07 дугаар сарын 06-ны өдөр</b> Цаг: <b>09 цаг 00 минут</b></p> <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>)-ийн серверийн цагаар тооцогдох тул хугацаа хоцорсон тохиолдолд тендерийн материал хүлээн авах боломжгүй. Тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө илгээсэн тендерийн материалаа буцаан засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.</p>

<p><b>ТӨӨЗ 2.1</b></p>	<p>Тендерийн нээлт хийх газрын хаяг нь дор өгөгдөв. Үүнд:          Байшин, гудамжны нэр: <b>4 дүгээр хороо, Бага тойруу-15, Нийслэлийн Засаг захиргааны IV байр.</b>          Давхар болон ерөөний дугаар: <b>10 дугаар давхар, 1012 тоот өрөө.</b>          Аймаг, хот: <b>Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг.</b>          Улс: <b>Монгол Улс.</b>          Тендерийн нээлт хийх огноо, цаг нь:          Огноо: <b>2020 оны 07 дугаар сарын 06-ны өдөр</b>          Цаг: <b>09 цаг 30 минут</b></p>
<p><b>ТӨӨЗ 2.3</b></p>	<p>Тендерт оролцогч дараах нэмэлт материалыг өөрийн тендерт хавсралтаар ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Тендерийн үнийн саналын маягтыг тендерийн баримт бичигт заасны дагуу бэлтгэж, баталгаажуулан ирүүлнэ.</li> <li>2. Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурах этгээдийн итгэмжлэлийг ирүүлнэ.</li> <li>3. Барааны жагсаалт ба бараа нийлүүлэлтийн хуваарийг маягтын дагуу баталгаажуулан ирүүлнэ.</li> <li>4. Холбогдох үйчилгээний жагсаалт ба гүйцэтгэлийн хуваарийг маягтын дагуу баталгаажуулан ирүүлнэ.</li> <li>5. Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл: <b>Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл эсвэл гэрээт борлуулагчийн итгэмжлэлийг маягтын дагуу ирүүлэх шаардлагатай.</b>          /Баталгаат орчуулгын товчоогоор орчуулж баталгаажуулсан байх/</li> <li>6. Татвар, нийгмийн даатгалын хэлтэс, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар болон холбогдох эрх бүхий байгууллагуудаас тодруулга авахад татгалзах зүйлгүй тухай албан бичиг ирүүлнэ.</li> <li>7. Барааны техникийн болон үйл ажиллагааны шинж чанарын дэлгэрэнгүй тодорхойлолт: Шаардлагатай.          Захиалагч болон нийлүүлэгчийн техникийн тодорхойлолтыг харьцуулсан байдлаар хүснэгтээр бэлтгэж баталгаажуулан ирүүлнэ.          Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтоос зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.</li> <li>8. Нийлүүлэх тоног төхөөрөмжийн үйлдвэрлэгчийн каталоги ирүүлэх, (Каталоги дээрээс санал болгож буй барааг ялган тодруулж ирүүлнэ.)</li> <li>9. Тендерт оролцогчийн ирүүлсэн саналыг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдүүлэг ирүүлнэ,</li> <li>10. Тендерийн баримт бичгийн 5, 6 дугаар бүлэгт заагдсан гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, маягт зэргийг хүлээн зөвшөөрч байгаа тухай мэдэгдэл ирүүлнэ,</li> <li>11. Тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ болон хугацаанд багтаан чанарын шаардлага хангасан барааг захиалагчид нийлүүлэх баталгааг албан бичгээр гаргаж ирүүлнэ,</li> <li>12. Тендерт оролцогч нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10' дугаар зүйл, Монгол улсын Засгийн газрын 2019 оны 90 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан барааны жагсаалтад багтсан бараа, бүтээгдэхүүнийг нийлүүлэх бол албан хүсэлт, нотлох баримтын хамт ирүүлнэ.</li> </ol>

	<p>13. ТООЗ-ны 4.2.1 - 4.2.9-д дурьдсан нөхцөл үүссэн эсэх тухай мэдэгдэл ирүүлнэ.</p> <p>14. Олон улсын худалдааны Incoterms/Инкотермс -ийн хувилбар: <b>“Incoterms 2010”</b></p> <p>15. Олон улсын чанарын CE, FDA, ISO, TUV зэрэг стандартын аль нэгийг хангасан эсэхийг гэрчилэх гэрчилгээ ирүүлнэ.</p> <p>Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна.</p> <p>16. Татварын тодорхойлолт ирүүлэх шаардлагагүй ба Татварын ерөнхий газрын цахим мэдээллийн сангаас тендер нээсэн өдрийн байдлаар татварын өр, төлбөрийн талаарх мэдээллийг шалгана.</p> <p>17. Харьяа дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсээс нийгмийн даатгалын шимтгэлийн өргүй тухай тодорхойлолт,</p> <p>18. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт,</p> <p>19. Хугацаа хэтэрсэн зээл болон зээлийн хүүгийн өргүй тухай харилцагч банкны тодорхойлолтыг улсын бүртгэлийн гэрчилгээнд заасан банк тус бүрээс ирүүлнэ.</p> <p>20. Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн тодорхойлолт ирүүлнэ. <i>/Энэхүү тодорхойлолтод Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4 дэх заалтын талаар тусгасан байна./</i></p> <p>21. Одоогийн ба сүүлийн 3 жилийн хугацаанд тендерт оролцогчийн оролцсон аливаа шүүхийн зарга, маргааны талаарх мэдээлэл: <b>Шүүхий ерөнхий зөвлөлийн төрөлжсөн архивын тодорхойлолт ирүүлнэ.</b></p> <p>Дээрх тодорхойлолтыг тендер зарлагдсан өдрөөс хойш авсан байх ба тендер нээсэн өдрийн байдлаар хүчин төгөлдөр байна</p> <p>Дээр заасан материалуудын аль нэгийг ирүүлээгүй буюу маягтын дагуу ирүүлээгүй тохиолдолд уг тендерээс татгалзах үндэслэл болно.</p>
<p><b>ТООЗ 6.2</b></p>	<p>Нэр: <b>Цэцэрлэгийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 17 дугаар хороо, 103 дугаар цэцэрлэг/ нийлүүлэх</b></p> <p>Дугаар: <b>НХААГ-20/0039-2</b></p> <p>Санхүүжилтийн эх үүсвэр нь: <b>Улсын төсвийн хөрөнгө</b></p> <p>Нийт төсөвт өртөг: 215,000,000 /хоёр зуун арван таван сая/ төгрөг</p>

## **Техникийн тодорхойлолт**

Цахим баримтаар хавсаргав



## Барааны жагсаалт ба бараа нийлүүлэлтийн хуваарь

*[Захиалагч энэхүү хүснэгтийн 1-7 хүртэлх баганыг, тендерт оролцогч 8 дугаар баганыг тус тус бөглөнө.]*

Нэр	Барааны тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг (Ажлын талбай)	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Бараа нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Бараа нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа (Тендерт оролцогч энэ баганыг бөглөнө)
1	2	3	4	5	6	7	8
<i>[Дугаар бичих]</i>	<i>[Барааны товч тодорхойлолтыг бичих]</i>	<i>[нэгжийн тоо ширхэгийг бичих]</i>	<i>[Хэмжих нэгжийг бичих]</i>	<i>[Бараа хүргэх газрын нэр]</i>	<i>[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]</i>	<i>[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]</i>	<i>[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]</i>
1	Зиг заг хулдаасан шал	68,9	М <sup>2</sup>	Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 17 дугаар хороо, 103 дугаар цэцэрлэг	30	45	
2	Таазны хөөс	68,9	М <sup>2</sup>		30	45	
3	Таазны хүрээ	36,3	метр		30	45	
4	Цавуу	16	ширхэг		30	45	
5	Паркет шал хүрээ	36,3	ширхэг		30	45	
6	Хувцасны шүүгээ	1	ширхэг		30	45	
7	Тайзны хөшиг	2	ком		30	45	
8	Паарны хаалт	7	ширхэг		30	45	
9	Хөгжмийн зэмсэг байрлуулах тавиур	1	ком		30	45	
10	Акустик эсгий хавтан	103	М <sup>2</sup>		30	45	
11	Ятга	2	ширхэг		30	45	



33	Цонхны хамгаалалтын төмөр	81	ширхэг		30	45	
34	Хогын сав дугуйтай	1	ширхэг		30	45	
35	Коридорын дроз Япон /Цавууны хамт/	238	М <sup>2</sup>		30	45	
36	Буйдан	1	ширхэг		30	45	
37	Коридорын сандал	3	хос		30	45	
38	Гэрэлтүүлэг	90	ком		30	45	
39	Шат	1	ширхэг		30	45	
40	Зөөврийн кварц гэрэл	1	ширхэг		30	45	
41	Зайнаас халуун хэмжигч	4	ширхэг		30	45	
42	Утлагын аппарат	1	ширхэг		30	45	
43	Агаарын чийг дулаан хэмжигч.	1	ширхэг		30	45	
44	Гадна талбайн тоглоом	2	ком		30	45	
45	Авиралтын тоглоом	2	ширхэг		30	45	
46	Нөөтбүк	26	ширхэг		30	45	
47	Өнгөт принтер	24	ширхэг		30	45	
48	Цаас зүсэгч	1	ширхэг		30	45	
49	Нуруулдагч	1	ширхэг		30	45	
50	Люминаторын машин	1	ширхэг		30	45	
51	Проектор	1	ширхэг		30	45	
52	Проекторын дэлгэц	1	ширхэг		30	45	
53	Багш шкаф	22	ширхэг		30	45	

54	Телевизор 40инч	10	ширхэг	Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 17 дугаар хороо, 103 дугаар цэцэрлэг	30	45	
55	Хөшиг /оффис өрөөнүүдэд/	20,4	М <sup>2</sup>		30	45	
56	Хөшиг/ангиудад/	123,7	М <sup>2</sup>		30	45	
57	Тоос сорогч	2	ширхэг		30	45	
58	Данх /5л/	12	ширхэг		30	45	
59	Тоглоомын тавиур	24	ширхэг		30	45	
60	Номын тавиур	20	ширхэг		30	45	
61	Кварц	20	ширхэг		30	45	
62	Тюль /хөшил/	102	М <sup>2</sup>		30	45	
63	Шүүгээ /гудас хөнжлийн/	8	ширхэг		30	45	
64	Дрож	17,3	М <sup>2</sup>		30	45	
65	Лего Тоглоом	20	ком		30	45	
66	Матрас	10	ширхэг		30	45	
67	Хананы авиралтын шат /3 төрөл/	1	ширхэг		30	45	
68	Хөнгөн Цагираг	22	ширхэг		30	45	
69	Сагсан бөмбөг	10	ширхэг		30	45	
70	Хөл бөмбөг	6	ширхэг		30	45	
71	Нүхтэй конус	10	ширхэг		30	45	
72	Спорт өрөлтийн цаг	2	ширхэг		30	45	
73	Вандан сандал	3	ширхэг		30	45	
74	Хөл бөмбөгийн хаалга	2	ширхэг		30	45	

75	Гар бөмбөгийн /хүүхдийн тор/	1			30	45	
76	Сагсны шит	3	КОМ		30	45	
77	Уулын авиралтын шат	2	КОМ		30	45	
78	Мөлхөлтийн хоолой	2	-		30	45	

## Холбогдох үйчилгээний жагсаалт ба гүйцэтгэлийн хуваарь

*[Энэхүү хүснэгтийг захиалагч бөглөнө. Үйлчилгээг гүйцэтгэх дуусах хугацааг аль болох бодитой байхаар тооцон, бараа нийлүүлэх хугацаатай уялдуулан тогтооно].*

1	2	3	4	5	6
Нэр төрөл	Үйлчилгээний талаархи тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	Үйлчилгээг гүйцэтгэх газар болон ажлын талбай	Үйлчилгээг гүйцэтгэж дуусгах огноо
Зиг заг хулдаасан шал	одоо ашиглаж байгаа програмд зохицож ажилладаг байх, суурилуулах, хэвийн ажиллагаанд оруулах,	68,9	М <sup>2</sup>	Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 17 дугаар хороо, 103 дугаар цэцэрлэг	Гэрээнд заасан хугацаанд
Таазны хөөс		68,9	М <sup>2</sup>		Гэрээнд заасан хугацаанд
Таазны хүрээ		36,3	метр		Гэрээнд заасан хугацаанд
Цавуу		16	ширхэг		Гэрээнд заасан хугацаанд
Паркет шал хүрээ		36,3	ширхэг		Гэрээнд заасан хугацаанд
Хувцасны шүүгээ		1	ширхэг		Гэрээнд заасан хугацаанд
Тайзны хөшиг		2	ком		Гэрээнд заасан хугацаанд
Паарны хаалт		7	ширхэг		Гэрээнд заасан хугацаанд
Хөгжмийн зэмсэг байрлуулах тавиур		1	ком		Гэрээнд заасан хугацаанд
Акустик эсгий хавтан		103	М <sup>2</sup>		Гэрээнд заасан хугацаанд
Ятга		2	ширхэг		Гэрээнд заасан хугацаанд
Шанз		1	ширхэг		Гэрээнд заасан хугацаанд
Ёочин		1	ширхэг		Гэрээнд заасан хугацаанд

Микрофон	одоо ашиглаж байгаа програмд зохицож ажилладаг байх, суурилуулах, хэвийн ажиллагаанд оруулах,	1	ширхэг	Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 17 дугаар хороо, 103 дугаар цэцэрлэг	Гэрээнд заасан хугацаанд
Моринхуур		1	ширхэг		Гэрээнд заасан хугацаанд
Лимбэ		1	ширхэг		Гэрээнд заасан хугацаанд
Мандалин		5	ширхэг		Гэрээнд заасан хугацаанд
Аппартур		1	ком		Гэрээнд заасан хугацаанд
Үкүлэлэ		5	ширхэг		Гэрээнд заасан хугацаанд
Хивс		1	М <sup>2</sup>		Гэрээнд заасан хугацаанд
Махны машин		1	ширхэг		Гэрээнд заасан хугацаанд
Бэлтгэлийн ширээ		1	ширхэг		Гэрээнд заасан хугацаанд
Дээжний хөргөгч		1	ширхэг		Гэрээнд заасан хугацаанд
Агуулахын тавиур		1	ширхэг		Гэрээнд заасан хугацаанд
Гурил, будааны төмөр сав/орос/		8	ширхэг		Гэрээнд заасан хугацаанд
Ногооны сагс		8	ширхэг		Гэрээнд заасан хугацаанд
Махны сагс /орос/		10	ширхэг		Гэрээнд заасан хугацаанд
6 хаалгатай хөргөгч		1	ширхэг		Гэрээнд заасан хугацаанд
Хөлдөөгч		1	ширхэг		Гэрээнд заасан хугацаанд
Хүнсний тавиур		1	ширхэг		Гэрээнд заасан хугацаанд
Ажилчдын хувцасны шкаф	30	ширхэг	Гэрээнд заасан хугацаанд		

Камер	одоо ашиглаж байгаа програмд зохицож ажилладаг байх, суурилуулах, хэвийн ажиллагаанд оруулах,	1	ком	Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 17 дугаар хороо, 103 дугаар цэцэрлэг	Гэрээнд заасан хугацаанд
Цонхны хамгаалалтын төмөр		81	ширхэг		Гэрээнд заасан хугацаанд
Хогын сав дугуйтай		1	ширхэг		Гэрээнд заасан хугацаанд
Коридорын дроз Япон /Цавууны хамт/		238	М²		Гэрээнд заасан хугацаанд
Буйдан		1	ширхэг		Гэрээнд заасан хугацаанд
Коридорын сандал		3	хос		Гэрээнд заасан хугацаанд
Гэрэлтүүлэг		90	ком		Гэрээнд заасан хугацаанд
Шат		1	ширхэг		Гэрээнд заасан хугацаанд
Зөөврийн кварц гэрэл		1	ширхэг		Гэрээнд заасан хугацаанд
Зайнаас халуун хэмжигч		4	ширхэг		Гэрээнд заасан хугацаанд
Утлагын аппарат		1	ширхэг		Гэрээнд заасан хугацаанд
Агаарын чийг дулаан хэмжигч.		1	ширхэг		Гэрээнд заасан хугацаанд
Гадна талбайн тоглоом		2	ком		Гэрээнд заасан хугацаанд
Авиралтын тоглоом		2	ширхэг		Гэрээнд заасан хугацаанд
Нөөтбүк		26	ширхэг		Гэрээнд заасан хугацаанд
Өнгөт принтер		24	ширхэг		Гэрээнд заасан хугацаанд
Цаас зүсэгч		1	ширхэг		Гэрээнд заасан хугацаанд
Нуруулдагч		1	ширхэг		Гэрээнд заасан хугацаанд



Люминаторын машин	одоо ашиглаж байгаа програмд зохицож ажилладаг байх, суурилуулах, хэвийн ажиллагаанд оруулах,	1	ширхэг	Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 17 дугаар хороо, 103 дугаар цэцэрлэг	Гэрээнд заасан хугацаанд
Проектор		1	ширхэг		Гэрээнд заасан хугацаанд
Проекторын дэлгэц		1	ширхэг		Гэрээнд заасан хугацаанд
Багш шкаф		22	ширхэг		Гэрээнд заасан хугацаанд
Телевизор 40инч		10	ширхэг		Гэрээнд заасан хугацаанд
Хөшиг /оффис өрөөнүүдэд/		20,4	М <sup>2</sup>		Гэрээнд заасан хугацаанд
Хөшиг/ангиудад/		123,7	М <sup>2</sup>		Гэрээнд заасан хугацаанд
Тоос сорогч		2	ширхэг		Гэрээнд заасан хугацаанд
Данх /5л/		12	ширхэг		Гэрээнд заасан хугацаанд
Тоглоомын тавиур		24	ширхэг		Гэрээнд заасан хугацаанд
Номын тавиур		20	ширхэг		Гэрээнд заасан хугацаанд
Кварц		20	ширхэг		Гэрээнд заасан хугацаанд
Тюль /хөшил/		102	М <sup>2</sup>		Гэрээнд заасан хугацаанд
Шүүгээ /гудас хөнжлийн/		8	ширхэг		Гэрээнд заасан хугацаанд
Дрож		17,3	М <sup>2</sup>		Гэрээнд заасан хугацаанд
Лего Тоглоом		20	ком		Гэрээнд заасан хугацаанд
Матрас		10	ширхэг		Гэрээнд заасан хугацаанд
Хананы авиралтын шат /3 төрөл/		1	ширхэг		Гэрээнд заасан хугацаанд

Хөнгөн Цагираг	одоо ашиглаж байгаа програмд зохицож ажилладаг байх, суурилуулах, хэвийн ажиллагаанд оруулах,	22	ширхэг	Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 17 дугаар хороо, 103 дугаар цэцэрлэг	Гэрээнд заасан хугацаанд
Сагсан бөмбөг		10	ширхэг		Гэрээнд заасан хугацаанд
Хөл бөмбөг		6	ширхэг		Гэрээнд заасан хугацаанд
Нүхтэй конус		10	ширхэг		Гэрээнд заасан хугацаанд
Спорт өрөлтийн цаг		2	ширхэг		Гэрээнд заасан хугацаанд
Вандан сандал		3	ширхэг		Гэрээнд заасан хугацаанд
Хөл бөмбөгийн хаалга		2	ширхэг		Гэрээнд заасан хугацаанд
Гар бөмбөгийн /хүүхдийн тор/		1	ширхэг		Гэрээнд заасан хугацаанд
Сагсны шит		3	ком		Гэрээнд заасан хугацаанд
Уулын авиралтын шат		2	ком		Гэрээнд заасан хугацаанд
Мөлхөлтийн хоолой		2	-		Гэрээнд заасан хугацаанд

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

**1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Үйлдвэрлэгч/гэрээт борлуулагчийн итгэмжлэл

[Тендерт оролцогч энд заасан зааврын дагуу үйлдвэрлэгч/гэрээт борлуулагчаар энэ маягыг бөглүүлсэн байна.Энэхүү итгэмжлэлийг үйлдвэрлэгч/гэрээт борлуулагчийн албан бланкан дээр бичиж, түүнийг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурсан байна.ТШӨХ-д шаардсан тохиолдолд тендерт оролцогч үүнийг тендерийн хамт ирүүлнэ.]

Огноо: [тендер ирүүлсэн (өдөр, сар, он)]

НТШ-ын дугаар: [оруул:тендер шалгаруулалтын дугаар]

Хувилбарын дугаар: [оруул:энэнь хувилбарт тендер бол ялгах дугаар]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

Бид, [оруул: үйлдвэрлэгч/гэрээт борлуулагчийн бүтэн хаяг]-д байршилтай [оруул: үйлдвэрлэгч/гэрээт борлуулагчийн бүрэн нэр] нь[оруул: үйлдвэрлэдэг/ борлуулдаг барааны төрөл]-ийг албан ёсоор үйлдвэрлэдэг/борлуулдаг бөгөөд, үүгээр [оруул: тендерт оролцогчийн бүтэн нэр] компанид бидний үйлдвэрлэсэн/борлуулсан [оруул: барааны нэр ба товч тодорхойлолт], барааг санал болгосон тендер ирүүлж, улмаар хэлэлцээр хийн гэрээ байгуулахыг зөвшөөрч байна.

Бид дээр дурдсан компанийн санал болгосон барааны хувьд Гэрээний ерөнхий нөхцөлийн 14-д заасны дагуу чанарын баталгааг бүрэн гаргаж байна.

Үйлдвэрлэгч/гэрээт борлуулагчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |  |   |
|--|---|
| 1. Шалгах болон турших                             | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.   |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх                                | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.  |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх     | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.  |
| 5. Баталгаат засварын хугацаа                      | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа <b>[моо]</b> жил байна.   |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах                        | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.   |
| 7. Төлбөр  | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш <b>[ГТН-д заасан моо]</b> хоногийн дотор шуурхай хийнэ.  |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь                         | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.   |
| 9. Алданги оногдуулах                              | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.  |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах         | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.   |
| 11. Маргааныг шийдвэрлэх                           | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.  |

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

<p><b>1. Шалгах болон турших (ГЕН – 1)</b></p>	<p>1.1. Нийлүүлэгч нь захиалагчид шалгаж хүлээлгэн өгнө. Нийслэлийн Боловсролын газраас томилогдсон ажлын комисс шалгаж хүлээн авна</p>
<p><b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)</b></p>	<p>2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;</li> <li>2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;</li> <li>3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;</li> <li>4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;</li> <li>5) барааны гарал үүслийн гэрчилгээ.</li> </ol> <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p>
<p><b>3. Баталгаат засвар (ГЕН-5)</b></p>	<p>5.1. Баталгаат засварын тусгай шаардлага. Баталгаат засварын хугацаа барааг хүлээлгэн өгсөн акт үйлдсэнээс хойш 12 сар байна.</p>
<p><b>4. Төлбөр (ГЕН – 7)</b></p>	<p>7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:</p>
	<p>Гэрээний үнийн дүнгийн <b>95</b> хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.</p> <p>Эцсийн төлбөрийг баталгаат засварын хугацаа дуусахад төлөх ба бараа эцэслэн хүргэгдсэний дараа нийлүүлэгч гэрээний үнийн дүнгийн <b>5 хувийн</b> дүнтэй тэнцэх банкны баталгааг захиалагчид гаргаж өгснөөр барьцаалсан мөнгийг урьдчилан олгоно.</p>
<p><b>5. Алданги оногдуулах (ГЕН - 9)</b></p>	<p>9.1 Алданги ногдуулах хувь: <b>Хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,5 хувь</b> байна. Алдангийн нийт дүн: <b>Гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 хувиас хэтрэхгүй</b> байна.</p>

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ	НИЙЛҮҮЛЭГЧ
_____	_____
(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
_____	_____
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
_____	_____
(Албан тушаал)	(Албан тушаал)

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_ сарын \_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_-наас \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт



бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]*\_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]*\_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*